



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/253

Номгон

Онцгой комиссын бүрэлдэхүүн, шуурхай ажлын хэсэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, аймгийн Онцгой комиссын 2023 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн “Онцгой комиссын бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Онцгой комиссын ажиллах журам”-ыг хоёрдугаар, “Шуурхай ажлын хэсэг”-ийг гуравдугаар, “Шуурхай ажлын хэсгийн ажиллах журам”-ыг дөрөвдүгээр, “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги”-ийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн Онцгой комисс, шуурхай ажлын хэсэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан гишүүдэд гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулж, гамшгийн үед нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын Орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д;

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (аймгийн Онцгой комиссын Гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан Орлогч дарга, хурандаа Ж.Алтангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.


4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/36 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2013 оны 11 дугаар
сарын 11-ний өдрийн 2253 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт




АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: 1.Аймгийн Засаг дарга;
- Орлогч дарга: 2.Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан орлогч;
- Үндсэн гишүүд: 3.Аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб хариуцсан орлогч;
- 4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- 5.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга;
- 6.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
- 7.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
- 8.Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
- 9.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;
- 10.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;
- 11.Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга;
- 12.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;
- 13.Цагдаагийн газрын дарга;
- 14.Тагнуулын хэлтсийн дарга;
- 15.Эрүүл мэндийн газрын дарга;
- 16.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга;
- 17.Мал эмнэлгийн газрын дарга;
- 18.“Баянхонгор- Эрчим хүч” ЦТХХК-ний захирал;
- 19.Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга;
- 20.“Чандмань-Баянхонгор” ХК-ийн захирал;
- 21.“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн салбарын дарга;
- 22.Улаан загалмайн хорооны дарга;
- 23.Авто тээврийн төвийн дарга;
- 24.Баянхонгор сумын Засаг дарга;
- Нарийн бичгийн дарга:-1 25.Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга;
- Өргөтгөсөн хэлбэрээр хуралдаан зохион байгуулах тохиолдолд дараах 26.Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч;
- 27.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар;
- 28.Нэгдсэн эмнэлгийн дарга;
- 29.Зоонозын өвчин судлалын төв;
- 30.Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга;
- 31.Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга;

бүрэлдэхүүн
нэмэлтээр
оролцоно:

- 32. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
- 33. Соёл урлагийн газар;
- 34. Сум дундын ойн ангийн дарга;
- 35. Сумдын дарга нар.

_____ ооо _____



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг төвлөрүүлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах, Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн дагуу хүч хэрэгслийг дайчлан ажиллуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавихад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2.Онцгой комисс үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3.Онцгой комиссын хурлыг аймгийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд, түүний эзгүйд орлогч дарга нар хуралдуулна.Комиссын хурал гишүүдийн 50-иас доошгүй хувь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

1.4.Онцгой комиссын дэргэд Шуурхай ажлын хэсгүүд ажиллана.Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүн, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийг Онцгой комиссын дарга баталж, үйл ажиллагаанд нь Онцгой комиссын орлогч дарга хяналт тавьж ажиллана.

1.5.Гамшгийн нөхцөл байдлын талаар Онцгой комиссын гишүүд санал боловсруулан Онцгой комиссын нарийн бичгийн даргаар уламжлуулан комиссын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.6.Онцгой комисс нь хууль тогтоомж, энэ журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж тогтоол, тушаал, албан даалгавар, хурлын тэмдэглэл гаргана.

1.7.Аймгийн Онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг, Төв штабын хуралдааны тэмдэглэл, үүрэг чиглэлийг хуралдаанаар асуудлыг шийдвэрлэж, аймгийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг болон дэс дугаараар албажуулна.

1.8.Онцгой комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.9.Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.10.Онцгой комиссын ажлын албаны чиг үүргийг Онцгой байдлын газар гүйцэтгэнэ. Комиссын өдөр тутмын ажлыг нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

1.11.Онцгой комиссын нарийн бичгийн дарга нь Онцгой комиссын гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

1.12.Онцгой комиссын гишүүдэд Онцгой комиссын даргын шийдвэрээр үнэмлэх, хөдөлмөр хамгааллын хувцас олгоно.

Хоёр. Онцгой комиссын эрх, үүрэг

2.1.Онцгой комисс дараах эрхтэй:

2.1.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад санал, холбогдох бусад байгууллагад үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

2.1.2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны үед хууль тогтоомжид заасны дагуу холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэдийг өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах;

2.1.3.Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай судалгаа тайлан, мэдээ, мэдээлэл гаргуулан аван, тайлан мэдээллийг хэлэлцэн шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулах;

2.1.4.Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

2.1.5.Гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үед онцгой шаардлагатай, хүн хүч, техник хэрэгслийг татан оролцуулах саналаа Улсын онцгой комисст уламжлан Зэвсэгт хүчин болон бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах;

2.2.Онцгой комисс дараах үүрэгтэй:

2.2.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн

захиргааны болон орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газар болон Улс, аймгийн Онцгой комиссын гаргасан тогтоол, шийдвэр, үүргийн хэрэгжилтийг хангах;

2.2.2.Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.2.3.Гамшигтай тэмцэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллага, аймгуудтай хамтран ажиллах, арга туршлагаа харилцан солилцох;

2.2.4.Гамшгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдуулан яам, Засгийн газрын агентлаг, мэргэжлийн байгууллагаас гаргасан санал, дүгнэлт, мэдээллийг хэлэлцэн шийдвэр гаргах;

2.2.5.Гамшиг болсон нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх болон хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг холбогдох дээд шатны байгууллагад танилцуулах;

2.2.6.Гамшгийн нөхцөл байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, мөн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, нутгийн захиргааны байгууллагууд, гамшгаас хамгаалах албадын мэдээллийг нэгтгэн дүгнэж, удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулан бодит мэдээлэл өгөх;

2.2.7.Гамшгийн голомтод хүмүүнлэгийн тусламж хүргэх, хуваарилах, тээвэрлэх явцад хяналт тавих;

2.2.8.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

2.2.9.Онцгой комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх.

2.2.10.Гамшгийн нөхцөл байдал хүндэрсэн үед Онцгой комиссын шуурхай штаб байгуулж, комиссын гишүүдийг хуваарийн дагуу ажиллуулах, тухайн

гамшгийн төрөл, үүссэн нөхцөл байдлаас хамаарч ажиллах журмыг Онцгой комиссын орлогч даргаар батлуулах.

Гурав. Онцгой комиссын гишүүний эрх, үүрэг

3.1. Онцгой комиссын гишүүн дараах эрхтэй:

3.1.1. Гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай үед комиссын хуралд асуудал танилцуулан холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх;

3.1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан захирамж, тушаал, журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврын биелэлтийг хангуулахтай холбогдсон асуудлаар харьяа нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжид нэвтрэх.

3.2. Онцгой комиссын гишүүн дараах үүрэгтэй:

3.2.1. Онцгой комиссын хуралд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх асуудлыг шийдвэрлүүлэх, гамшгийн голомтод зохих журмын дагуу нэвтэрч, үйл ажиллагааг нь шалгаж, заавар, зөвлөгөө өгөх;

3.2.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан захирамж, тушаал, журам, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах;

3.2.3. Сумдын Онцгой комиссын ажлыг шалгах, заавар, зөвлөгөө өгөх, санал, хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэх, дээд шатны байгууллагад танилцуулах.

Дөрөв. Онцгой комиссын зардал

4.1. Онцгой комисс аймгийн нутаг дэвсгэрт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ.

4.2. Аймгийн Засаг даргын нөөцөөс хөрөнгөөс давсан хохирол үүссэн үед тухайн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардлыг Улсын Онцгой комисст хандан шийдвэрлүүлнэ.

Тав. Хяналт хариуцлага

5.1. Аймгийн Онцгой комисс ажлын тайлангаа хагас, бүтэн жилээр Улсын Онцгой комисст танилцуулна.


5.2. Аймгийн Онцгой комиссын гишүүн нь албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тохиолдолд

Төрийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3.Аймгийн Онцгой комиссын хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслах, бусад гишүүдийг хуралдаанд оролцохгүй байхыг уриалах зэрэг зөрчил дутагдал гаргасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____ ооо _____

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 32 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСЭГ

1. Газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх шуурхай ажлын хэсэг:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 32 дугаар захирамжаар томилогдсон “Газар хөдлөлтийн гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн”-ийн гишүүд.

2. Үер, ус, цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Аймгийн Засаг даргын орлогч;
Орлогч дарга:-1	-Онцгой байдлын газрын орлогч;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн;
Гишүүд:-8	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
	-Цагдаагийн газрын дарга;
	-Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч;
	-Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн захирал;
	-Чандмань-Баянхонгор ХК-ийн захирал;
	-Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга;
Нэмэлтээр:	-Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга.

3. Объектын болон ой хээрийн түймрийн үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Онцгой байдлын газрын дарга;
Орлогч дарга:-1	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч;
Гишүүд:-5	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
	-Цагдаагийн газрын дарга,
	-Баянхонгор-Эрчим хүч ЦТӨХК-ийн захирал,
	-Чандмань-Баянхонгор ХК-ийн захирал,
Нэмэлтээр:	Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга, байгууллага, аж ахуй нэгжийн дарга.

4. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Онцгой байдлын газрын орлогч;
Орлогч дарга:-2	-Эрүүл мэндийн газрын дарга,
	-Мал эмнэлгийн газрын дарга,
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах

Гишүүд:-9	төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, -Цагдаагийн газрын дарга, -Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, -Тагнуулын хэлтсийн дарга, -Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга,
Нэмэлтээр:	-Нэгдсэн эмнэлгийн дарга; -Зоонозын өвчин судлалын төвийн дарга, -Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга.

5. Дэд бүтэц, техникийн холбогдолтой ослын үед ажиллах шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Аймгийн Засаг даргын орлогч,
Орлогч дарга:-2	-Аймгийн Онцгой комиссын Нарийн бичгийн дарга;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн;
Гишүүд:-6	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, -Цагдаагийн газрын дарга, -Соёл, урлагийн газрын дарга, Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч, -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, -Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн захирал, -Хот тохижилт ОНӨААТҮГ-ын захирал, -Чандмань-Баянхонгор ХК-ийн захирал,
Нэмэлтээр:-1	-Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга, байгууллага, аж ахуй нэгжийн дарга.

6. Цацраг, химийн аюулын үед ажиллах шуурхай ажлын хэсэг

Дарга:-1	-Тагнуулын хэлтсийн дарга;
Орлогч дарга:-1	-Аймгийн Онцгой комиссын Нарийн бичгийн дарга;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн;
Гишүүд:-6	-Эрүүл мэндийн газрын дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга; -Цагдаагийн газрын дарга; -Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч; -Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга;
Нэмэлтээр:-1	Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга, байгууллага, аж ахуй нэгжийн дарга.

7. Зуд, өвөлжилт хүндэрсэн үед ажиллах шуурхай ажлын хэсэг

Дарга:-1	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;
Орлогч дарга:-1	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн;
Гишүүд:-6	-Эрүүл мэндийн газрын дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга; -Цагдаагийн газрын дарга; -Мал эмнэлгийн газрын дарга; -Сум дундын ойн ангийн дарга;
Нэмэлтээр:-1	Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга.

8. Хүнсний хангамжийн нөөц бүрдүүлэх шуурхай ажлын хэсэг

Дарга:-1	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;
Орлогч дарга:-1	- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Ахлах нягтлан бодогч;
Гишүүд:-7	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга; -Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга; -Эрүүл мэндийн газрын дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга; -Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын Баянхонгор аймаг дахь төлөөлөгч; - Хүнс хөдөө аж ахуйн газрын хэлтсийн дарга; - Улаан загалмайн хорооны дарга; -Сумдын Засаг дарга;
Нэмэлтээр:-2	-Баянхонгор сумын "Дэлгүүрүүдийн холбоо"-ны дарга, -Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга.

9. Нүүлгэн шилжүүлэлт, тусгаарлах байрны шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;
Орлогч дарга:-2	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга; -Автотээврийн төвийн дарга;
Нарийн бичиг:-1	-Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн;
Гишүүд:-7	-Цагдаагийн газрын дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга; -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга; -Биеийн тамир, спортын газрын дарга; -Эрүүл мэндийн газрын дарга;
Нэмэлтээр:-2	-Ариутгал халдваргүйжүүлэлт хийх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуй нэгжийн удирдлага; -Тухайн асуудалтай холбогдсон сумдын Засаг дарга.

10. Санхүү, нөөц бүрдүүлэлт, дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах,хуваарилах шуурхай ажлын хэсэг:

Дарга:-1	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
----------	--

- Орлогч дарга:-2 -Онцгой байдлын газрын орлогч;
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга;
- Нарийн бичиг:-1 -Онцгой байдлын газрын Ахлах нягтлан бодогч;
- Гишүүд:-6 - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга;
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга;
-Улаан загалмайн хорооны дарга.

11. Аймгийн Онцгой комиссын Төв штаб:

Аймгийн Засаг дарга болон Онцгой комиссын хуралдааны тухайн үеийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

-----oO-----

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар
сарын 11 нийгэдрийн 233 дугаар
захирамжийн 4 дүгээр хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Онцгой комиссын шуурхай ажлын хэсэг (цаашид шуурхай ажлын хэсэг гэх) нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын аюулаас хүн, ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Шуурхай ажлын хэсэг нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, захирамж, тушаал, бусад хууль тогтоомж болон энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаа явуулна.

1.3. Шуурхай ажлын хэсгээс гарсан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.4. Шуурхай ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг тухайн ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга дарга хариуцна.

Хоёр. Шуурхай ажлын хэсгийн үүрэг

2.1. Гамшиг, осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлэх, Монгол Улсын Шадар сайд, Улс болон аймгийн Онцгой комиссоос энэ чиглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих.

2.2. Гамшиг, осол, аюулт үзэгдлийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.4.Гамшиг, осол, аюулт үзэгдлийн цагийн байдалд мэргэжлийн байгууллагын өгсөн үнэлэлт, дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг хэлэлцэж шийдвэр гаргах.

2.5.Гамшиг, осол, аюулт үзэгдлээс үүссэн нутаг дэвсгэр, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас дайчлан гаргасан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн асуудлаар санал боловсруулж аймгийн Онцгой комисст танилцуулж, шийдвэрлүүлэх.

2.6.Гамшиг, осол, аюулт үзэгдлийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, үүссэн нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай аймгийн Онцгой комисст танилцуулж, холбогдох албан тушаалтнуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангаж, мэдээллийг нэг цонхны системээр дамжуулах.

2.8.Гамшиг, осол, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг аймгийн Онцгой комисст танилцуулж, шийдвэрлүүлэх.

2.9.Шуурхай ажлын хэсэг нь гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэмд заасны дагуу чиглэл тус бүрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх.

Гурав.Шуурхай ажлын хэсэг нь дараах эрхтэй.

3.1.Гамшиг, осол, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагын удирдлагад үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд хяналт тавих.

3.2.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

3.3.Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж шийдвэр гаргаж биелүүлэхийг шаардах.

3.4.Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

3.5.Гамшиг, осол, аюулт үзэгдлийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчин болон бусад хүчний байгууллагуудын анги, салбарын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг дайчлан ажиллуулах саналыг дээд шатны төрийн захиргааны төв байгууллагаас нь зөвшөөрөл авч дайчлан ажиллуулах.

3.6.Гамшиг, осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардлыг тооцож дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.7.Шуурхай ажлын хэсгээс олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох хууль, дүрмийн дагуу татан оролцуулах.

Дөрөв.Шуурхай ажлын хэсгийн гишүүний үүрэг:

4.1.Хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулж шийдвэрлүүлэх.

4.2.Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Улс, аймаг, сум, дүүргийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах.

4.3.Аймгийн Засаг даргын захирамжаар томилгоожсон гамшгаас хамгаалах алба, ажлын хэсэг болон аж ахуйн нэгж, байгууллагын орон тооны бус штабын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, гүйцэтгэсэн ажлынхаа талаар ажлын хэсэгт албан ёсоор танилцуулах.

Тав.Шуурхай ажлын хэсгийн гишүүний эрх:

5.1.Аймгийн гамшгаас хамгаалах нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшиг, осол, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник, хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн хуралд асуудал танилцуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал тавьж шийдвэрлүүлэх.

5.2.Гамшгаас хамгаалах тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн

болон төрийн бус байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэх.

Зургаа. Шуурхай ажлын хэсгийн үйл ажиллагааны зардал:

6.1. Шуурхай ажлын хэсэг нь нутаг дэвсгэртээ гамшиг, осол, аюулт үзэгдлийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг аймгийн Онцгой комиссын танилцуулан шийдвэрлүүлж, зохих журмын дагуу захиран зарцуулна.

6.2. Шуурхай ажлын хэсгийн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой шуурхай хуралдаанаас гарсан бичиг хэргийн зардлыг тухайн ажлын хэсгийн Нарийн бичгийн даргын хамаарал бүхий байгууллага хариуцна.


Долоо. Бусад зүйл

7.1. Шуурхай ажлын хэсэг нь гамшиг, осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнг үүссэн нөхцөл байдал дууссаны дараа ажлын 3 хоногийн дотор аймгийн Онцгой комисст танилцуулна.

7.2. Гамшиг, осол, аюулт үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах, хор уршгийг арилгах чиглэлээр гаргасан аливаа шийдвэрийг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэхгүй байхыг бусдад уриалсан байгууллага, албан тушаалтныг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, аж ахуйн нэгж, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тус тус хариуцлагын арга хэмжээ тооцно.

7.3. Ажлын хэсэг нь хурлын тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 1253 дугаар захирамжийн 5 дугаар хавсгалт



ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИ

Д/Д	Гамшгаас хамгаалах алба	Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги	Түшиглэн байгуулах мэргэжлийн байгууллагууд
1	Хэв журам сахиулах, замын тээврийн хөдөлгөөн зохицуулах алба	1.Нийтийн хэв журам сахиулах мэргэжлийн анги	Цагдаагийн газар
		2.Тээврийн цагдаагийн мэргэжлийн анги	
		3.Мөрдөн байцаах мэргэжлийн анги	
2	Холбоо зарлан мэдээлэл дамжуулах алба	4.Харилцаа, холбооны мэргэжлийн анги	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК, МЦХолбоо ХК, Мобиком ХХК, Юнител ХХК, Скайтел ХХК, Жи- Мобайл ХХК
		5.Зарлан мэдээллийн мэргэжлийн анги	
		6.Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжлийн анги	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хэвлэл мэдээллийн алба (Номгон ТВ, Хонгор ТВ, ТВ-10 телевиз, радио FM-106.5)
3	Нүүн шилжих, нүүлгэн шилжүүлэлтийн алба	7.Нүүлгэн шилжүүлэлтийн түр болон хорогдох байраар хангах мэргэжлийн анги	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Биеийн тамир, спортын газар
		8.Нүүлгэн шилжүүлэлт тээвэр зохицуулалтын мэргэжлийн анги	Авто тээврийн төв
4	Эрүүл мэндийн алба	9.Эрүүл мэндийн удирдлагын мэргэжлийн анги	Эрүүл мэндийн газар
		10.Яаралтай тусламжийн мэргэжлийн анги	Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Төв эмийн сан
		11.Хээрийн эмнэлгийн мэргэжлийн анги	
		12.Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах мэргэжлийн анги	
13.Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжлийн анги	Соёл урлагийн газар (Хөгжимт драмын театр, Тэмүүжин театр)		

5	Мал эмнэлгийн алба	14.Мал эмнэлгийн мэргэжлийн анги	Мал эмнэлгийн газар
6	Нийгмийн хамгааллын алба	15.Нийгмийн хамгааллын удирдлагын мэргэжлийн анги	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс
		16.Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги	Гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газар
		17.Эрсдэлт бүлгийг хамгаалах мэргэжлийн анги	Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга
		18.Бүх шатны Боловсролын мэргэжлийн анги	Боловсрол, шинжлэх ухааны газар
		19.Сайн дурын хэсгийн мэргэжлийн анги	Улаан загалмайн хороо
7	Хүнс, хөдөө аж ахуйн алба	20.Хүнсний нөөц, хангалтын мэргэжлийн анги	Хүнс, хөдөө аж ахуйн газар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар
		21.Мал аж ахуй, бэлчээрийн зохицуулалтын мэргэжлийн анги	Хүнс, хөдөө аж ахуйн газар
8	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн алба	22.Уул уурхайн удирдлага, хүч хэрэгсэл хариуцсан мэргэжлийн анги	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
9	Гамшгаас хамгаалах механикжуулсан алба	23.Механикжуулсан мэргэжлийн анги	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги
		24.Авто зам, гүүр хариуцсан мэргэжлийн анги	"Их Богд" ХХК
10	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	25.Химийн аюулыг үнэлж, мэдээлэх мэргэжлийн анги	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
		26.Байгаль, цаг агаарын нөхцөл байдлыг үнэлж, мэдээлэх мэргэжлийн анги	

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН
МЭРГЭЖЛИЙН АНГИ**

Д/д	Мэргэжлийн ангийн зориулалт	Хариуцах байгууллага
1	Эрчим хүчээр хангах тусгай зориулалтын мэргэжлийн анги	Баянхонгор эрчим хүч ЦТХХК
2	Ус, дулаанаар хангах тусгай зориулалтын мэргэжлийн анги	Чандмань-Баянхонгор ХХК
3	Нисэх буудлын тусгай зориулалтын мэргэжлийн анги	ИНЕГ-ын Баянхонгор аймаг дахь нисэх буудал
4	Эрэн хайх, аврах, гал түймэр унтраах тусгай зориулалтын мэргэжлийн анги	Баянхонгор сум дахь Эрэн хайх, аврах бүлэг
		Баянхонгор сум дахь Гал түймэр унтраах, аврах 16 дугаар анги